



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2022.07.27 № ЦАТ-11/03/026 .

танай 2022.06.28 -ны № \_\_\_\_\_ -г

Агентын өөрчлөлтийг бүртгэсэн тухай

Танай компаниас агентын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлт, холбогдох баримт бичиг ирүүлснийг Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу хянахад, агент Гантөмөрийн Бямбасүрэн нь тус Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байх тул хасах боломжгүй болохыг мэдэгдье.

Дээрх журмын 6.5-д “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн агент өөрчлөгдөх, шинээр томилогдсон тухай мэдээллийг албан бичгээр улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлж, бүртгүүлнэ” гэж заасны дагуу агентын өөрчлөлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлж ажиллахыг анхаарна уу.

Жич: Хорооны цахим хуудсанд байршсан танай компанийн агентуудын мэдээллийг шинэчилсэн болно.

